



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2016 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 186


Улаанбаатар хот

Авто замын салбарын техникийн
баримт бичгүүд батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, "Авто замын тухай" хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Авто зам замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох заавар"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдсан жишиг техникийн шаардлага болон зааврыг 2016 оны 7 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Авто замын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Доржханд/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /П.Билгүүн/-т тус тус даалгасугай.
3. Батлагдсан жишиг техникийн шаардлага болон зааврыг "Зам, тээврийн салбарын норматив баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох сан"-гийн хөрөнгийн эх үүсвэрээр хэвлэн олшруулж, нийтийн хүртээл болгохыг тус сангийн Удирдах зөвлөлд үүрэг болгосугай.
4. "Зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох заавар" батлагдаж буйтай холбогдуулан дараах тушаал болон тушаалын хавсралтуудыг хүчингүй болсонд тооцсугай. Үүнд:
 - а. ЗТБХБ-ын сайдын 2011 оны 7-р сарын 18-ны өдрийн 200 дугаар тушаалаар баталсан "Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв зохиох заавар";
 - б. "Тарифт цалингийн жишиг шинэчлэн батлах тухай" ЗТБХБ-ын сайдын 2009 оны 9-р сарын 25-ны өдрийн 263-р тушаал;
 - в. ЗТБХБ-ын сайдын 2007 оны 11-р сарын 20-ны өдрийн 186-р тушаалын 4, 5-р хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



М.ЗОРИГТ